



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/234

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 3 дугаар хуралдааны 3/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Малын эрүүл мэнд ” дэд хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдах ажилд тусгагдсан 40.000.000 төгрөгийг зарцуулж, төсвийн задаргааг хавсралтаар баталсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулах 40.000.000 төгрөг / дечин сая /-ийг орон нутгийн хөгжлийн сангийн төсөл, хөтөлбөр арга хэмжээний санхүүжилтээс олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. Дээрх арга хэмжээнд зарцуулах 40.000.000 төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, тайлагнаж ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга /Д.Батцэнгэл/-д даалгасугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны 5 дугаар
сарын 13-ны өдрийн А/234 дүгээр
захирамжийн хавсралт

МАЛЫН ЭРҮҮЛ МЭНД ДЭД ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТИЙН
ТӨСВИЙН ЗАДАРГАА

Д/д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Малын шилжилт хөдөлгөөний босоо, хэвтээ тэнхлэгийн замын хяналтын цэгийн тэмдэг тэмдэглэгээ	20 ш	150,000	3,000,000
2	Дарви, Булган, Мянгад, Манхан, Жаргалант сумдын хяналтын постонд мэдээллийн самбар	5 ш	500,000	2,500,000
3	Малын гоц халдварт өвчний тархвар зүйн зураглал	20 ш	425,000	8,500,000
4	Лабораторийн шинжээч эмч нарын нарийн мэргэжлийн сургалтанд хамруулах /PCR, шинжилгээ, Илийза шинжилгээ/	5 малын эмч	600,000	3,000,000
5	Баруун бүс нутгийг эрүүл бүс болгоход судалгааны ажлын хэвлэл, мэдээллийн зардал	4 хэвлэлийн байгууллага	500,000	2,000,000
6	Мөст сумын мал эмнэлгийн тасгийн байрны засвар үйлчилгээ ажил	1 ш	6000,000	6000,000
7	Ковид-19 цар тахлын үед ашиглах ариутгал халдваргүйтгэлийн Дук машины төхөөрөмж засварлах	1 ш	7450,000	7450,000
8	Малчдад зориулж мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилт, эмийг зохистой хэрэглэж хангуулах үе шаттай сургалт	8 сум	437,500	3,500,000
9	Вакцин хадгалах бага оврын хөргүүр	10 ш	405,000	4,050,000
				40,000,000